

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

2017 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар: Д-2017-03

*Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл  
бүхий талбайд хайгуулын ажил гүйцэтгэгч  
хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр  
дүнгийн тайлан, нөөцийн тооцоололд өгөх  
зөвлөмжийн төслийг хэлэлцсэн тухай*

Хувийн хөрөнгөөр ашигт малтмалын хайгуулын ажил гүйцэтгэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд өгөх зөвлөмжийн төслийг хэлэлцсэн гишүүдийн саналыг үндэслэн дараах ЗӨВЛӨМЖ-ийг гаргаж байна.

1. ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ирүүлж байгаа нөөцийн тооцоолол бүхий үр дүнгийн тайлан нь АМТХ-ийн 4-р зүйлийн 4.1.25 дахь заалтыг бүрэн хангасан байх,
2. Нөөцийн тайланд тусгагдсан нөөц, түүний ангилал нь Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-тай нийцсэн байх,
3. Нөөцийн тайлан нь АМГ (хуучин нэрээр)-ын даргын 2009 оны 414 дүгээр тушаалаар баталсан “Ашигт малтмалын ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн агуулга, түүнд тавих шаардлага”-ыг нөөцийн тайлан бичих, боловсруулах нэгдсэн зааврын дагуу бичигдсэн байх,
4. Геологийн бичиглэл буюу давхаргазүйн бичиглэлийг шинээр батлагдсан стратиграфийн кодексийн дагуу хийж гүйцэтгэх
5. Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тооцооллыг тухайн чиглэлээр эрх авсан мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй хээрийн судалгаанд биечлэн оролцсон туршлага бүхий мэргэжилтэн боловсруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх,
6. Ашигт малтмалын ордын нөөцийн тооцоололд орох дээж, сорьцын лабораторийн шинжилгээний гадаад хяналт (3-10 хүртлэх хувь)-ыг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх, гарсан үр дүнд нь харьцуулалт хийж шалгасан байх,
7. Тогтоосон нөөцийн хянан баталгаажуулах ажлыг заавал хийсэн байх.
8. Тухайн нөөцийн тооцоолол хийсэн ашигт малтмалын дагалдах ашигт бүрдлийн судалгааг заавал хийсэн байх,
9. Дагалдах ашигт бүрдвэрийн агуулга, нөөцийг хүдэрт болон баяжмалд тооцоолсон байх,
10. Технологийн туршилтыг олон улсын эсвэл үндэсний стандарчилал бүхий лабораториор заавал хийлгэсэн байх.

**ТАНИЛЦСАН:**

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА,  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

  
Б.БААТАРЦОГТ

**ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:**

УУХУЯ-НЫ ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ХУРАЛДААНЫ ДАРГА

  
Д.ГАНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН,  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

  
Н.ОЮУНЦЭЦЭГ